



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/21

Халбан

**Орон тооны бус байнгын зөвлөлийг  
татан буулгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их хурлаас нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/77 дугаар тушаалаар баталсан "Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм"-ээр зохицуулж байсан харилцааг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын дагуу аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын дэргэдэх "Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл"-өөр шийдвэрлэх болсон тул Засаг даргын Тамгын газрын дэргэдэх орон тооны бус зөвлөлийг татан буулгасугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/142 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3. Уг зөвлөлийн хуралдаанаас гарсан иргэний баримт материалыг архивын нэгж үүсгэн Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлэхийг зөвлөлийн дарга, Нарийн бичгийн дарга нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Д.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

